

**Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/1/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: Saranmuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	16
4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022.02.24 № 10.

танай _____ -ны № _____ -г

АЙМГИЙН "ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН"-ГИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Х.БУЯНБАЯР
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020030

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	405,139,700.00	386,979,090.00
33	АВЛАГА	405,139,700.00	386,979,090.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	402,162,200.00	345,664,500.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	136,785,400.00	154,419,000.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	36,667,800.00	33,970,000.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	69,499,000.00	48,570,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	144,800,000.00	88,740,500.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	14,410,000.00	19,965,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,977,500.00	41,314,590.00
2	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (II) БУС	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	405,139,700.00	386,979,090.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	159,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	159,700.00
41300	Өглөг	-	159,700.00
41360	Бусад өглөг	-	159,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	159,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	405,139,700.00	386,819,390.00
51	Засгийн газрын хувь оролцоо	405,139,700.00	386,819,390.00
51200	Хуримтлагдсан үр дүн	405,139,700.00	386,819,390.00
51210	Өмнөх үеийн үр дүн	371,912,514.00	402,162,200.00
51220	Тайлант үеийн үр дүн	33,227,186.00	- 15,342,810.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	405,139,700.00	386,979,090.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	333,115,396.00	313,909,359.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,361,296.00	1,144,359.00
1200	Өмчийн орлого	17,361,296.00	1,144,359.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,361,296.00	1,144,359.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	17,361,296.00	1,144,359.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,754,100.00	312,765,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,250,600.00	312,765,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,218,500.00	5,974,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	109,032,100.00	306,791,000.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	203,503,500.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	203,503,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	299,888,210.00	329,252,169.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,888,210.00	329,252,169.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,903,660.00	4,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,913,660.00	-
210401	Бичиг хэрэг	3,357,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,636,160.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	157,500.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,762,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,990,000.00	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг	2,990,000.00	4,000,000.00

Говьсүимбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ажил үйлчилгээний төлбөр хураамж		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,984,550.00	325,252,169.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,433,796.00	1,144,359.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,433,796.00	1,144,359.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,978,986.00	5,974,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,256,986.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,722,000.00	5,974,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	145,700,314.00	174,017,800.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,700,314.00	174,017,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,871,454.00	144,116,010.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,871,454.00	144,116,010.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	33,227,186.00	- 15,342,810.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	33,227,186.00	- 15,342,810.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	405,139,700.00	-	405,139,700.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 2,977,500.00	-	- 2,977,500.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	402,162,200.00	-	402,162,200.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-

Говьсүимбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт		-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз		-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	15,342,810.00	-	- 15,342,810.00
16	ҮЛДЭГДЭЛ		386,819,390.00	-	386,819,390.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	478,865,710.00	313,909,359.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,111,610.00	1,144,359.00
1200	Өмчийн орлого	163,111,610.00	1,144,359.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	163,111,610.00	1,144,359.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	145,750,314.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	17,361,296.00	1,144,359.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,754,100.00	312,765,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,250,600.00	312,765,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,218,500.00	5,974,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	109,032,100.00	306,791,000.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	203,503,500.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	203,503,500.00	-
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	186,497,700.00

145	Бусад орлого (олз)	-	186,497,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	478,865,710.00	500,407,059.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,865,710.00	500,407,059.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,032,100.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	475,833,610.00	496,407,059.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,361,296.00	13,624,259.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,361,296.00	13,624,259.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,978,986.00	5,974,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,256,986.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,722,000.00	5,974,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	145,750,314.00	202,852,490.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,750,314.00	202,852,490.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	295,743,014.00	273,956,310.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	295,743,014.00	273,956,310.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	86,497,700.00
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	186,497,700.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	186,497,700.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	-	186,497,700.00

	ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
--	-------------------------------	--	--

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлан он		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,569,200	277,956,310	48,612,890
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,569,200	277,956,310	48,612,890
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,000,000	4,000,000	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000	4,000,000	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000	4,000,000	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	322,569,200	273,956,310	48,612,890
2132	Бусад урсгал шилжүүлэг	322,569,200	273,956,310	48,612,890
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	322,569,200	273,956,310	48,612,890
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	326,569,200	306,791,000	19,778,200
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,569,200	306,791,000	19,778,200
131001	Улсын төсвөөс санхүүжих	326,569,200	306,791,000	19,778,200

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,032,100	277,956.310
21	УРСГАЛ ЗАРДАЛ	102,032,100	277,956.310
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,032,100	4,000.000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,032,100	4,000.000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,032,100	4,000,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000,000	273,956,310
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000,000	273,956,310
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,000,000	273,956,310
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	112,250,600	306,791.000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,250,600	306,791.000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112,250,600	306,791.000
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/41 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр нийгэм халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах

Тайлант онд 7 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлж, 96.2 хувийн биелэлтэй ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 299,88.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,998.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,399.0 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,160.6 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, өглөг, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			0.0
Авлага	405,139.7	386,979.1	-18,160.6
Урьдчилгаа			0.0
Бараа материал			0.0
Үндсэн хөрөнгө			0.0
Нийт хөрөнгө	405,139.7	386,979.1	-18,160.6
Өр төлбөр		159.7	159.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	405,139.7	386,819.4	-18,320.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	405,139.7	386,979.1	-18,160.6

Авлага дансны үлдэгдэл 386,979.1 мянган төгрөг болж 18,160.6 мянган төгрөгөөр буурсан нь зээлдэгч нарын зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Авлагын эхний үлдэгдэл 405,139.7 мянган төгрөг байснаас тайлант хугацаанд 37 иргэнд олгосон зээл 130,000.0 мянга, үндсэн дансны төвлөрүүлэлт 12,479.9 мянга, нэмэлт дансны төвлөрүүлэлт 28,834.7 мянга, нийт 171,314.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, зээлийн эргэн төлөлт 186,497.7 мянга, өмнөх оны санхүүжилтийн авлага 2,977.5 мянга, нийт 189,475.2 мянган төгрөгөөр буурч, 386,979.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Өглөгийн үлдэгдэл 159.7 мянган төгрөг нь байгууллагад шилжүүлсэн гүйлгээ буцаж ондоо багтаж залруулга хийгдээгүйгээс өглөгөөр тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 386,819.4 мянган төгрөг болж 18,320.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны санхүүжилтийн авлага хаасан 2,977.5 мянга, тайлант хугацааны үр дүн 15,342.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 19,206.0 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлого 2,989.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орлого 16,217.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 29,363.9 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал өссөн нь тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг дэмжсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү санхүүжилтийн авлага 2,977.5 мянган төгрөгийг бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн залруулга хийсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 471,054.0 мянга, нийт зарлагыг 471,054.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 184,714.8 мянган төгрөгөөр бууруулж, 286,339.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 286,339.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор ажлын чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний зардлыг 4,850.0 мянга, ажил олгогчид олгох дэмжлэгийг 6,000.0 мянга нийт 10,850.0 төгрөгөөр бууруулж, иргэн, аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох зардлыг 10,080.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад нь дэмжлэг үзүүлэх зардлыг 10,000.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэгийн 8,000.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлыг 23,000.0 мянга, нийт 51,080.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 326,569.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “72102-хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” 1 хөтөлбөрийн хүрээнд 82616-ЗГ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр төслийг санхүүжүүлэхээр 326,569.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 326,569.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 306,791.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 19,778.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд 277,956.3 мянган төгрөг зарцуулж, 28,834.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 277,956.3 мянган төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь төрөөс олгох тэтгэмж урамшууллын зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 306,791.0 мянга, хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн санхүүжилт 5,974.0 мянга, туслах үйл ажиллагааны

орлого 1,144.3 мянга, нийт 313,909.3 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 306,791.0 мянга, хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн санхүүжилт 5,974.0 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1,144.3 мянга, зээлийн эргэн төлөлт 186,497.7 мянга, нийт 500,407.0 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжилт 306,791.0 мянга, хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн санхүүжилт 5,974.0 мянга, нийт 312,765.0 мянган төгрөгийг орлого бүрдүүлж, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 273,956.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,000.0 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 34,808.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийг жил бүр батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгохгүй байгаа зөрчил давтагдсаар байна. Үүнд:

- 2020 онд 1,632.1 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү, 2021 онд 19,778.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу тус тус санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 14 дугаар 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул холбогдох дээд төсвийн захирагчид уламжлах саналтай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” нь 2021 онд нийт 779,557.0 мянган төгрөгийн 33 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгогдсоныг сүүлийн төсвийн хуваарьтай тулган баталгаажуулж байх зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	1,632.1	1	1,632.1	-	-	-
Нийт дүн	1	1,632.1	1	1,632.1	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон 33 иргэний 39,173.1 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт зээлийн гэрээний хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн нь анхаарал татахуйц асуудал байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,015.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 159.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 159.7 мянган төгрөгийн 1 алдааг завсрын аудитаар залруулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд зарлагыг 159.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан

4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага өгөгдөөгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ХЭДС-гийн орлогын төлөвлөгөөг 855.6 мянган төгрөгөөр дутуу биелүүлж ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Орлогын төлөвлөгөөг биелүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	1,105.3	1	159.7	0	0	0	0	1	855.6